

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

АУДИТЫН КОД: ТӨА-2023/03/НА-СТА-ОНА

БАРИЛГА ЗАХИАЛАГЧ, ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ-
ЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод хот 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК

Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа	10
3.2 Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	18
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	19
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ИТХТХ	Иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хурал
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.24 № 01/219

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны орлогын төлөвлөгөөний биелэлт 58.2 хувьтай, 2,523.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Зуунмод сумын 2022 оны А/117 дугаар захирамжаар нь Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын удирдах зөвлөлийг байгуулсан.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Засаг даргыг төлөөлж, Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батжаргал Үйлдвэрийн газрын даргатай 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г байгуулсан байна. Гэрээний 1 дүгээр хавсралтаар 2022 оны бизнес төлөвлөгөөг 405,642.2 мянган төгрөгийн орлоготой, 336,549.7 мянган төгрөгийн зардалтай, 69,092.5 мянган төгрөгийн нийт ашигтай ажиллахаар баталснаас 235,921.3 мянган төгрөгийн орлоготой, 239,194.1 мянган төгрөгийн зардал гаргаж, 4,945.5 мянган төгрөгийн адагдалтай ажилласан байна.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлын 2022 онд байгуулсан онцгой нөхцөл бүхий гэрээнд тусгагдсан 22 үүргийн биелэлт 100.0 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

19040229

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,145,559.63	13,540,665.37
1.1.6	Бараа материал	3,927,320.00	4,057,520.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	7,072,879.63	17,598,185.37
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	39,072,249.33	24,629,289.33
1.2.2	Биет бус хөрөнгө	806,666.66	1,334,666.66
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	39,878,915.99	25,963,955.99
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	46,951,795.62	43,562,141.36
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.3	Татварын өр	-	1,555,825.54
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	1,555,825.54
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	1,555,825.54
2.3	Эзэмшигчдийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- Хувьцаат	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	45,951,795.62	41,006,315.82
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	46,951,795.62	42,006,315.82
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	46,951,795.62	43,562,141.36

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	167,220,070.00	235,921,349.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	167,220,070.00	235,921,349.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	167,677,799.85	219,194,104.33
11	Санхүүгийн зардал	49,400.00	-
12	Бусад зардал	1,752,692.00	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(20,000,000.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,259,821.85)	(3,272,755.33)
19	Орлогын татварын зардал	-	1,672,724.47
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,259,821.85)	(4,945,479.80)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(2,259,821.85)	(4,945,479.80)
24	Орлогын нийт дүн	(2,259,821.85)	(4,945,479.80)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	-	48,211,617.47	48,211,617.47
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	-	1,000,000.00
тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(2,259,821.85)	(2,259,821.85)
2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	1,000,000.00	45,951,795.62	46,951,795.62
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	45,951,795.62	46,951,795.62
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(4,945,479.80)	(4,945,479.80)
2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	1,000,000.00	41,006,315.82	42,006,315.82

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	157,130,240.00	235,937,189.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	157,130,240.00	235,571,349.00
	Бусад мөнгөн орлого	-	365,840.00
1.2	Мөнгөн зарлага (-)	158,786,480.21	215,782,083.26
	Ажиллагчдад төлсөн	86,136,616.00	125,503,981.75
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	22,635,177.74	31,434,049.50
	Бараа материал худалдан авахад төлсөн	5,408,730.00	2,822,560.00
	Ашиглалтын зардалд төлсөн	2,215,040.00	2,815,785.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,243,210.00	18,786,250.00
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	12,080,806.47	9,985,687.01
	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
	Бусад мөнгөн зарлага	22,066,900.00	24,433,770.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,656,240.21)	20,155,105.74
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,236,800.00	9,760,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13,356,800.00	8,880,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	880,000.00	880,000.00
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,236,800.00)	(9,760,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(15,893,040.21)	10,395,105.74
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,038,599.84	3,145,559.63
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,145,559.63	13,540,665.37

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны гүйцэтгэл	2022 оны төсвийн төсөл	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
Орлого	167,220,070	405,642,182	235,937,189	169,704,993	58.2
Нийт орлого	167,220,070	405,642,182	235,937,189	169,704,993	58.2
I. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН /урсгал зардал+ХО зардал/	173,023,280	336,549,648	238,460,994	114,706,748	70.9
II. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	173,023,280	336,549,648	238,460,994	114,706,748	70.9
Бараа үйлчилгээний зардал	173,023,280	336,549,648	238,460,994	114,706,748	70.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92,781,169	167,846,515	131,809,180	36,037,335	78.5
Үндсэн цалин	92,781,169	167,846,515	131,809,180	36,037,335	78.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,770,292	20,980,814	16,523,435	4,457,379	78.8
Тэтгэврийн даатгал	-	14,266,954	11,235,936	3,031,018	78.8
Тэтгэмжийн даатгал	-	1,678,465	1,321,875	356,590	78.8
ҮОМШ өвчний даатгал	-	1,342,772	1,057,500	285,272	78.8
Ажилгүйдлийн даатгал	-	335,693	264,375	71,318	78.8
Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	-	3,356,930	2,643,750	713,181	78.8
Байгууллагын тогтмол зардал	240,000	1,020,000	598,150	421,850	58.6
Цэвэр, бохир ус	-	240,000	-	240,000	0.0
Гэрэл цахилгаан	-	180,000	-	180,000	0.0
Түлш, халаалт	-	600,000	-	600,000	0.0
Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	20,565,459	35,388,843	32,540,525	5,827,298	92.0
Тээвэр (шатахуун)	9,124,210	15,712,243	19,386,250	38,083	123.4
Шуудан, холбоо	1,697,149	3,415,600	1,732,855	1,682,745	50.7
Бичиг хэрэг	2,481,200	3,536,000	2,762,420	40,470	78.1
Ном, хэвлэл авах	-	325,000	134,000	191,000	41.2
Биеийн тамирын уралдаан, тэмцээн	1,646,000	2,400,000	2,310,000	90,000	96.3
Программ хангамж	880,000	2,200,000	880,000	1,320,000	40.0
Эрүүл мэнд, Тэтгэмж	4,736,900	7,800,000	5,335,000	2,465,000	68.4
Эд хогшлын зардал	14,512,780	15,070,000	8,575,000	6,495,000	56.9
Эд хогшил худалдан авах	9,210,700	12,950,000	8,575,000	4,375,000	66.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл авах	5,302,080	2,120,000	-	2,120,000	0.0
Томилолт зочны зардал	12,003,000	17,974,500	15,972,700	2,001,800	88.9
Дотоод албан томилолт	7,428,000	11,614,500	11,562,100	52,400	99.5
Хичээл, сургалт, семинар, хурал, зочны зардал	575,000	6,360,000	4,410,600	1,949,400	69.3
Бараа үйлчилгээний бусад зардал	18,058,586	78,268,975	32,442,004	58,867,935	41.4
Техникийн нөхцөл, магадлал	12,230,691	14,726,400	2,742,464	5,024,900	18.6
Аудитын зэрэглэл тогтоох үйлч.хөлс	588,000	588,000	588,000	-	100.0

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Газрын төлбөр	2,464,815	2,243,575	1,729,140	514,435	77.1
Тээврийн хэрэгслийн зардал	277,880	6,035,000	3,390,000	2,645,000	56.2
Зар сурталчилгааны зардал	2,497,200	4,576,000	3,935,200	640,800	86.0
Төв аймаг 100 жил ой угтсан ажил	-	50,000,000	-	50,000,000	0.0
Автомашин акталсан	3,042,594		20,000,000		
Дансны шимтгэл	49,400	100,000	57,200	42,800	57.2
УРСГАЛ ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, ҮР ДҮН	(2,251,822)	69,092,534	(2,523,805)	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО		1	1	1	
АЖИЛЛАГСАД БҮГД		12	10		
Гүйцэтгэх ажилтан		9	7	2	
Үйлчлэх ажилтан		2	2		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын зорилго нь: “Барилгын зураг төсөв, техникийн норм, дүрмийг дагаж мөрдүүлэх, зөв зохистой төлөвлөн зарцуулах, чанартай материал хийц эдлэлээр барилга бариулах, орон нутгийн иргэдийг орон сууцжуулах талаар баримтлах бодлого стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх” гэж тодорхойлжээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит ААТҮГазар статустай Зуунмод сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын харьяа байгууллага байна.

Үйлдвэрийн газрын дүрэмд “Газрын /ОНӨААТҮГ-ын өмчлөгч нь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь аймгийн засаг дарга болон үйлдвэрийн газрын удирдах зөвлөл байна” гэж тодорхойлжээ. Үйлдвэрийн газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Бүтээн байгуулалт, барилгын ажлын зураг төсөв, санхүүг зохистой төлөвлөн зарцуулах чанартай хийц эдлэлээр барилгыг бариулах;
- Зураг төсөв, техникийн норм дүрмийг дагаж мөрдүүлэх болон далдлагдах ажлыг шалгах баталгаажуулах;
- Барилга байгууламжийн гүйцэтгэгч байгууллагаас гаргасан зөрчил, дутагдлыг засуулах ажлын гэрээт хугацааг чанд мөрдүүлэх;
- Барилга байгууламжийг чанартай ашиглалтад оруулахад техникийн хяналт тавихаас гадна холбогдох байгууллага, аж ахуйн нэгжтэй ерөнхий захирагчийн өмнөөс үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, орон нутгийн иргэдийг орон сууцжуулах талаар баримтлах бодлого, стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- Зуунмод хотын газрын нөөцийг үр ашигтай төлөвлөн эргэлтэд оруулах замаар хотын суурьшлын бүсийг хөгжүүлэх, бага, дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангах, орон сууцны нөхцөлийг сайжруулах, орон сууц нийлүүлэх, ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах; зэрэг аймгийн орон сууц, дахин төлөвлөлтийн асуудлыг нэгтгэн зохион байгуулах;

3.2 Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ыг Төв аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 121 дүгээр тогтоолоор, “Төв аймгийн орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-т нэгтгэн “Төв аймгийн барилга захиалагч, орон сууцны корпораци орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, газрын дүрэм, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4-т “Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих...” гэсэн заалттай нийцэж байна.

“Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Тайлант хугацаанд Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт дараах өөрчлөлт орсон байна.Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д” Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол;
- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нөлөөгүй байна.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын дүрмийн 3.4-т” Үйлдвэрийн газар нь үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэж , ажиллах журмыг Удирдах зөвлөл батална “ гэж заасан байна. Дотоод хяналтын багийн ажиллах журам, ажлын төлөвлөгөөг батлаагүй, гүйцэтгэсэн ажлын тайлангүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт, заавар журмыг бүрэн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллага нь НБББББ-гүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 904.3 мянган төгрөгөөр буюу 10.2 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,145.6	13,540.6	10,395.0
Авлага	-	-	-
Бараа материал	3,927.3	4,057.5	130.2
Үндсэн хөрөнгө	39,878.9	25,964.0	(13,914.9)
Нийт хөрөнгө	46,951.8	43,562.1	(3,389.7)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	46,951.8	43,562.1	(3,389.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	46,951.8	43,562.1	(3,389.7)

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс өссөн байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 10,395.0 мянган төгрөгөөр өссөн нь нийт орлого өмнөх оноос өссөн нь нөлөөлсөн.
- Бараа материалын дансны үлдэгдэл 130.2 мянган төгрөгөөр өссөн нь 22,911.0 төгрөгийн бараа материалыг худалдан авч, 22,780.2 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13,914.9 мянган төгрөгөөр буурсан нь Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 62 дугаар тогтоолоор 1 ш Прадо -120 автомашиныг худалдаж, 9,760.0 мянган төгрөгийн компьютер, тавилга эд хогшил худалдан авснаас шалтгаалсан байна.
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 4,945.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдлыг бүртгэж тайлагнаснаас шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын захирал Зуунмод сумын засаг даргатай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний нэгдүгээр хавсралтаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 405,642.2 мянган төгрөгөөр, нийт зардлыг 336,549.6 мянган төгрөгөөр, 69,092.5 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна..

Нийт орлогын гүйцэтгэл 235,937.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 169,705.0 мянган төгрөгөөр буюу 58.2 хувиар буурсан нь Үндсэн үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 238,461.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 113,264.9 мянган төгрөгөөр дутуу буюу 70.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ -ын үйл ажиллагааг сайжруулах, төрийн хэмнэлтийн хуультай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-нь 2022 оны санхүүгийн тайлангаа Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дугаар сарын 27-ны өдрийн 24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр ... сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **Дунд** гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 219,311.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,193.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,535.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар баталсан бодлого чиглэл гаргаж батлаагүй байна. Нийт батлагдсан 12 орон тоо баталснаас 10 орон тоотойгоор 2 орон тоо, дутуу ажиллаж, 27,293.8

мянган төгрөгийн хэмнэлт гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 155 мэдээлэл байршуулахаас 153 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг хугацаа хоцроож, ... хөрөнгө, мөнгө зарцуулах 3 удаагийн 2,961.6 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Дотоод хяналтын төлөвлөгөө, ажиллах журамгүй, дотоод хяналт хийгдээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Дотоод хяналтын ажиллах журмыг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 2,257.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 153,718.8 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 98.1 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний гэрээний хэрэгжилт, үр дүнг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 340,449.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулав.Үүнд:

- Үндсэн хөрөнгө данснаас хассан гарз 20,000.0 мянган төгрөгийг татвар ногдох орлогоос хасаж тооцоноос аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1,555.8 мянган төгрөгөөр дутуу бүртгэж,тайлагнасныг;

Аудитаар нийт 404.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 404.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Томилолтын зардлыг шилжүүлэхдээ 96.0 мянган төгрөгийг тооцоноос илүү шилжүүлж, 6 ажилтанд томилолтын хоногийг илүү тооцож 240.0 мянган төгрөг, нийт 336.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Засгийн Газрын 2019 оны 6 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2.4 -т "...Албан томилолтоор явсан,буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын батламж мэдэгдлийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд нэг ажилтны нэмэгдэл хөлсийг 68.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын батламж мэдэгдлийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Тайланд оны батлагдсан орлогын төлөвлөгөөг 169,705.0 мянган төгрөгөөр тасалдуулж, 4,945.5 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж ашгийн төлөвлөгөөг биелүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2/-т "Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин", 20 дугаар зүйлийн 3/-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11" Хууль

тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн Албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт

Үйлдвэрийн газар нь НБББББ-гүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны онцлог, стандарт, хууль дүрэмд нийцүүлэн НБББББ-т өөрчлөлт оруулан батлуулж мөрдөх.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 удгаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах," гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гэрээтэй холбоотой асуудал

Илрүүлэлт

Гэрээт ажлын 2,000.0 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлэхдээ гэрээний заалтыг баримтлаагүй, гүйцэтгэсэн ажлыг хүлээн авсан актгүйгээр төлбөрийг урьдчилан бүрэн шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө", 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:" 14.4.3-т " бүх өр төлбөр" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аливаа гэрээний төлбөрийг шилжүүлэхдээ гэрээний нөхцөлийг баримталж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Үндсэн хөрөнгө данснаас хассан гарз 20,000.0 мянган төгрөгийг татвар ногдох орлогоос хасаж тооцсоноос аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1,555.8 мянган төгрөгөөр дутуу бүртгэж, тайлагнасныг;	1	1,555.8	1	1,555.8			1	1,555.8				
Дүн	1	1,555.8	1.0	1,555.8	-	-	1.0	1,555.8	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Томилолтын зардлыг шилжүүлэхдээ 96.0 мянган төгрөгийг тооцсоноос илүү шилжүүлж, 6 ажилтанд томилолтын хоногийг илүү тооцож 240.0 мянган төгрөг, нийт 336.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон байна.	1	336.0	1	336.0								
Тайлант онд нэг ажилтны нэмэгдэл хөлсийг 68.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.	1	68.2	1	68.2								
Үйлдвэрийн газар нь НБББББ-гүй байна.	1	-					1	-				
Гэрээт ажлын 2,000.00 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлэхдээ гэрээний заалтыг баримтлаагүй, гүйцэтгэсэн ажлыг хүлээн авсан актгүйгээр төлбөрийг урьдчилан бүрэн шилжүүлсэн байна.	1	2,000.0	1	-			1	2,000.0				
Дүн	4	2404.2	3	404.2	0	0	2	2,000.00				

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 155 мэдээлэл байршуулахаас 153 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг хугацаа хоцроож, ... хөрөнгө, мөнгө зарцуулах 3 удаагийн 2,961.6 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байна.	1	2,961.6					1	2,961.6
Дүн	1	2,961.6					1	2,961.60
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайланд оны батлагдсан орлогын төлөвлөгөөг 169,705.0 мянган төгрөгөөр тасалдуулж, 4,945.5 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж ашгийн төлөвлөгөөг биелүүлээгүй байна.	1	174,650.5			1	174,650.5		
Дотоод хяналтын төлөвлөгөө, ажиллах журамгүй, дотоод хяналт хийгдээгүй байна.	1	-					1	-
Дүн	2	174,650.5	0	0	1	174,650.5	1	-
НИЙТ ДҮН	3	174,650.5	0	0	1	174,650.5	2	2,961.60